

УАНС-НЭЗДС-ын Бүсийн хүрээний төсөл – Нэмэлт санхүүжилт II

Байршил:
Бүс нутаг

Төслийн дугаар:
52401

Бизнесийн салбар:
Санхүүгийн байгууллагууд

Мэдэгдлийн төрөл:
Хаалттай

Байгаль орчны ангилал:
Санхүүгийн зууч байгууллагууд (FI)

Батлагдах тов:
2021 оны 3 дугаар сарын 10

Төлөв байдал:
Үзэл баримтлалыг хянасан

Төслийн хураангуй баримт бичиг (ТХББ)-ийг англи хэлээр танилцуулсан огноо:
2021 оны 2 дугаар сарын 1

Төслийн танилцуулга

ЕСБХБ болон Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гаас хамтран тус Банкны Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэр (НЭЗДС)-ээр дамжуулан олгодог санхүүжилтийн багцын хоёр дахь нэмэлт (“Нэмэлт санхүүжилт II”) төсөл. НЭЗДС нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд зохицон хөрвөхөд чиглэсэн төслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд нь зориулж, ЕСБХБ-ны үйл ажиллагааны орнууд дахь санхүүгийн байгууллагуудад зээлийн санхүүжилт олгодог эх үүсвэр юм. Энэхүү төсөл нь УАНС болон НЭЗДС-ын хамтарсан Бүсийн хүрээний төсөл (Төслийн дугаар 50233)-ийн хоёр дахь нэмэлт арга хэмжээ болж байна.

“Нэмэлт санхүүжилт II” нь 497 сая хүртэлх ам.долларын санхүүгийн багц нэмж хуваарилах төсөл бөгөөд түүний 373 сая ам.долларыг ЕСБХБ-ны ердийн эх үүсвэрээс, 124 сая хүртэлх ам.долларыг Ногоон уур амьсгалын сангаас гаргаж, Армян, Египет, Гүрж, Йордан, Молдав, Монгол, Морокко, Серб, Тажикистан, Тунис гэсэн орнууд дахь Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилтийн эх үүсвэрийн хүрээнд олгоно.

“Нэмэлт санхүүжилт II” төслөөр ЕСБХБ-ны Ногоон эдийн засгийн шилжилтийн бодлогыг дэмжсэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд зохицон хөрвөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийхэд нь зориулж, хувийн хэвшлийн компани, хувь хүмүүс, орон сууцны хоршоо, уур амьсгалын чиглэлийн өндөр үр дүнтэй технологийн ханган нийлүүлэгч, борлуулагч, үйлчилгээ үзүүлэгч нарт дамжуулан зээлдүүлэх

хөрөнгийг эрх бүхий орнууд дахь шаардлага хангасан санхүүгийн байгууллагуудад санхүүжилт болгон олгох ажил үргэлжлэх юм.

Төслийн зорилго

“Нэмэлт санхүүжилт II” нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд зохицон хөрвөхөд чиглэсэн санхүүжилтийн шинэ зах зээл бий болгох, байгаа зах зээлийг мэдэгдэхүйц томруулахад хувь нэмэр оруулах ажлыг үргэлжлүүлнэ. Ингэснээр, ЕСБХБ-ны “Ногоон эдийн засгийн шилжилтийн арга зам” бодлогын стратегийн зорилгыг хангахад тус дэм болох юм.

Тус арга хэмжээгээр аж үйлдвэр, худалдаа, орон сууц, тээвэр болон хөдөө аж ахуйн салбарын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд зохицон хөрвөх чиглэлд томруулах, хуулбарлан ашиглах боломжтой 6,500 гаруй төслийн санхүүжилтэнд дэмжлэг үзүүлж, хамрах хүрээг нь өргөтгөнө. Мөн технологийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд тулгардаг зах зээлийн олон тооны саад бэрхшээлийг шийдвэрлэж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын боломжийг нээж өгөх юм.

Шилжилтийн нөлөө

УАНС-НЭЗДС-ын хамтарсан Бүсийн хүрээний төслийн хүрээнд “Нэмэлт санхүүжилт II” арга хэмжээгээр дамжуулан олгох санхүүжилтийн гурав дахь удаагийн хуваарилалт нь ЕСБХБ-наас хөрөнгө оруулалт хийсэн 10 орны эдийн засгийг байгаль орчны хувьд тогтвортой, нүүрсхүчлийн хий багатай, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй болгох шилжилтийг цаашид хөхиүлэн дэмжих бөгөөд ингэснээр эдгээр орныг нүүрсхүчлийн хий ихээхэн ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, байгаль орчныг сүйтгэх бохирдол ихтэй замаар хөгжихөөс сэргийлж чадах болно. “Уур амьсгал”-ын чиглэлээр өндөр үзүүлэлттэй технологи, шийдлүүдийг санхүүжүүлэх санхүүгийн зуучлагч байгууллагуудад хөрөнгө санхүүжилт, ноу-хау олгох замаар энэ ажлыг гүйцэтгэх юм.

Үйлчлүүлэгчийн мэдээлэл

Зээлдэгчид нь санхүүжилт авах эрх бүхий улс орнуудад үйл ажиллагаа явуулж буй банк, бичил санхүүгийн байгууллага, лизингийн компаниуд зэрэг дотоодын санхүүгийн байгууллагууд байна.

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

373,000,000.00 ам.доллар

Төслийн нийт өртөг

373,000,000.00 ам.доллар

“Нэмэлт санхүүжилт II” төсөлд ЕСБХБ-ны өөрийн эх үүсвэрээс 373 сая ам.доллар, Ногоон уур амьсгалын сангаас 124 сая хүртэлх ам.доллар нэмж хуваарилна.

Нэмэлт ашиг тус

УАНС-НЭЗДС-ын хамтарсан Бүсийн хүрээний төсөлд хамрагдах дотоодын санхүүгийн байгууллагууд болон тэдний үйлчлүүлэгчид нь ногоон дэд төслүүдийг тодорхойлох, үнэлэх, санхүүжүүлэх чадавхиа сайжруулахад техник тусламж авснаар ашиг тус хүртэнэ. Дотоодын санхүүгийн байгууллагууд мөн УАНС-НЭЗДС-ын хамтарсан Бүсийн хүрээний төслийн жендэрийн мэдрэмжтэй арга хандлагыг сайжруулах талаар ЕСБХБ-ны хуримтлуулсан туршлагыг ашиглах, өөрчлөгдөж байгаа уур амьсгалын нөхцөлд хүндрэлийг тэсвэрлэн гарах чадавхи бүрдүүлэхэд нь дамжуулан зээлдэгч нартаа туслах боломжтой болно.

Байгаль орчин, нийгмийн шаардлагын тойм

Санхүүгийн зуучлагч (FI) ангилалд багтсан (ESP 2019). НЭЗДС-ын санхүүжилт нь байгаль орчны чиглэлээр томоохон боломж олгодог. Дотоодын санхүүгийн байгууллагууд нь ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн 2, 4, 9 дэх шаардлагуудыг дагаж мөрдөх, түүний дотор 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого (ESP 2019)-ын баримт бичгээр нэвтрүүлсэн хориглох үйл ажиллагааны өргөтгөсөн жагсаалт, ЕСБХБ-нд урьдчилан танилцуулах шаардлага (Referral Requirement)-ыг баримтлан ажиллах үүрэгтэй. Шаардлага хангасан дэд төслүүд нь байгаль орчин, нийгэм, хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаарх үндэсний хууль тогтоомжууд, мөн шаардлагатай бол ЕСБХБ-ны байгаль орчны болон нийгмийн шалгууруудад нийцсэн байх ёстой.

Аливаа дотоодын санхүүгийн байгууллага шинээр хамрагдах бол санхүүгийн зуучлагч байгууллагад зориулсан Байгаль орчин, нийгмийн асуудлаарх хяналтын асуумжийг бөглөж, ЕСБХБ-ны Байгаль орчин, тогтвортой байдлын департаментэд хүргүүлэн, Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцэж байгаа эсэхээ хянуулах ёстой. Дотоодын санхүүгийн бүх байгууллага жил дутмын Байгаль орчин, нийгмийн салбарын тайлангаа ЕСБХБ-нд танилцуулж, дэд төслүүдийн талаар болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, зохицон хөрвөх үйл ажиллагаанаас тэдний хүртэж байгаа ашиг тусын талаар илтгэх үүрэг хүлээнэ.

Техник хамтын ажиллагаа, буцалтгүй тусламжийн санхүүжилт

Чадавхи бий болгох, маркетинг, төслийн үнэлгээ, ерөнхий мониторинг хийх, тайлагнахад туслах зориулалт бүхий, ойролцоогоор 24 сая ам.долларын өртөгтэй техник хамтын ажиллагааны багц тусламжаар “Нэмэлт санхүүжилт II” төслийг дэмжиж ажиллана. Мөн үүнтэй зэрэгцэн, ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийн дизайн, маркетингийн асуудалтай холбогдох жендэрийн онцлогтой нийлүүлэлт, эрэлтийн хүрээн дэх саад тотгорыг шийдвэрлэхэд туслах зорилгоор жендэрийн асуудлыг зохицуулах бүрэлдэхүүн хэсгийг төслийн хүрээнд хэрэгжүүлэх болно.

Төслийн хураангуй баримт бичгийг шинэчилсэн огноо

2021 оны 2 дугаар сарын 1

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга барилын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хийх бизнесийн боломжууд (худалдан авах үйл ажиллагаатай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авах ажиллагаа](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн тухайд харилцагчдын дагаж мөрдөх ёстой үндэсний хууль тогтоомжийн холбогдох шаардлагуудад нийцүүлэх, мөн оролцогч талуудын санаа зовнил, гомдол, ялангуяа харилцагч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн харилцагчдадаа тухайн төслийн улмаас үүссэн эрсдэл, үр нөлөөллийн тухай зохих мэдээллийг ил болгох, эсвэл оролцогч талуудтай чухал ач холбогдолтой байдлаар зөвлөлдөх, тэднээс ирүүлсэн санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу илгээх нэмэлт шаардлага тавьдаг. Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг арга туршлагын талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Шударга ёс ба Хянан нийцүүлэлт

ЕСБХБ-ны Хянан нийцүүлэлт хариуцсан Захирлын Ажлын алба (ХНЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг арга туршлагад нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаанд шударга ёсыг хамгийн дээд түвшинд хангахад анхаардаг.

Төслүүд нь Банкинд шударга ёс, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд Банк бүх харилцагчиддаа шударга ёсны магадлах шалгалт хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны ажил гүйлгээний шударга ёсыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. ХНЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэх ба төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах шударга ёсны эрсдэлийг хянахад тус болдог.

Түүнчлэн, ХНЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга болон хууль бус үйлдлийн талаарх мэдэгдлийн мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд дотроос эсвэл гаднаас залилан мэхлэлт болон авилга үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй хэн ч гэсэн Хянан нийцүүлэлт хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаягаар бичгээр мэдэгдэл илгээх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлуудын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг ХНЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүхий л мэдэгдлийг шалгана. Мэдэгдлийг Банкны үйл ажиллагаанд ашиглагддаг буюу үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын үалбан ёсны хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь шударга үнэн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил болгох, уг бодлого 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг заана. ЕСБХБ-ны вэб хуудаснаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдэхийн тулд [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтийг [ЕСБХБ-ны Лавлагааны Маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв Харилцагч эсвэл Банкинд хамаатай байгаль орчны, нийгмийн буюу мэдээллийг олон нийтэд ил болгохтой холбоотой асуудлыг шийдвэрлэх оролдлого, хүчин чармайлт нь (жишээлбэл: Харилцагчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харьцах замаар) амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд өөрсдийн санал гомдлыг ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ) –аар дамжуулан шийдвэрлүүлэхийг эрмэлзэж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан гэж үзэж буй (эсвэл учруулж болзошгүй) асуудлуудыг хараат бусаар шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчны, нийгмийн болон мэдээллийг олон нийтэд ил болгохтой

холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлд Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлцлийг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#) эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс ирээдүйд эдгээр бодлогуудад үл нийцсэн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ нэгэнт бий болсон зөрчлүүдийг арилгаж шийдвэрлэхэд оршино.

Манай [нууц онлайн маягт](#) –ыг ашиглан, [цахим шуудан](#)-гаар, [шуудан эсвэл утсаар хэрхэн Өргөдөл, гомдол гаргах талаар мэдэхийг хүсвэл](#) Төслийн хариуцлагын хараат бус механизмын [вэб хуудсанд хандана уу](#). ТХХБМ нь таны санааг зовоосон асуудлын талаар ярилцах, Өргөдөл, гомдол мэдүүлэх, түүнийг [Төслийн хариуцлагын бодлого](#) ба [Удирдамж](#) –ийн дагуу хэрхэн хянан шийдвэрлэх тухайд таны бүхий л асуултанд хариулахад бэлэн байна. Өргөдөл, гомдол гаргагчдын хувийн мэдээллийг хүсэлтийн дагуу нууцалж болно.